

## ЯПОНЫ ЗЭЭЛ ТУСЛАМЖ

Ц. Баатар

Япон эдийн засгийн хүч чадал, хөгжлөөрөө дэлхийн хоёр дахь их гүрэн билээ. Тийм ч учраас Их долоогийн дунд ихээхэн нэр хүндтэй байр суурь эзэлдэг. Эдүгээ япон нь дэлхийн эдийн засгийн эрчимтэй хөгжлийн шилдэг загвар. хүчирхэг зүтгүүрийн бодит жишээ болжээ.

Японы эдийн засгийн өсөлт 1960—1970 онд жилдээ 10 хувиас дээш байсан бол сүүлийн жилүүдэд буурч ирсэн бөгөөд 1993 оны өсөлт 0,1 хувь, 1994 онд 0,6 хувь болон сэргэж байна. 1994 оны байдлаар Японы ННБ 469 триллион иен болсон нь АНУ-ын 68,3 хувьд хүрчээ. Хүн ам тутамд оногдох ННБ 1993 онд Японд 33903 ам.доллар болсон бол АНУ 25009, Хятад 458, Орост 387 доллар байна. Өргөн хэрэгцээний барааны үнэд холбогдох инфляцийн түвшин сүүлийн 5 жилд 1,6—3,3 хувь төдий байна.

Эдийн засгийнхан хүч чадал өсөн нэмэгдэхийн хирээр Азийн болон дэлхийн буурай хөгжилтэй орнуудад үзүүлдэг тусламжийнхаа хэмжээг тасралтгүй нэмэгдүүлсээр ирэв.

Японы Засгийн газраас хөгжиж буй орнуудын хөгжил дэвшилд зориулан 1994 онд 13,24 тэрбум ам. долларын тусламж үзүүлэв. 1989 оноос хойш Япон улс буурай хөгжилтэй оронд үзүүлдэг тусламжийн хэмжээгээр дэлхийд тэргүүлж явна. 1994 оны эцсийн байдлаар Японы гадаад орнуудад олгосон зээл дэлхийн санхүүгийн том төвүүдээс олгосон зээлийн 40 хувьтай тэнцэх болов.

Япон техникийн хамтын ажиллагааны тусламжаа Азийн орнуудад 1954 оноос үзүүлж эхэлсэн билээ. 1978 оноос Японы Засгийн газрын тусламж 70—75 тэрбум ам.доллар болох ажээ.

Японы тусламжийг эдийн засгийнхаа тулгамдсан амин чухал зүйлд зориулалтын дагуу зөв хяналттай зарцуулж хүнд байдлаас богино хугацаанд гарч өөдлөн хөгжсөн улс орон өнөөдөр олон арваараа тоологдох боллоо. Тухайлбал энд Зүүн Азийн орнуудыг нэрлэж болох юм.

Японы тусламж авсан өнгөрсөн 40 жилд Зүүн Азийн орнуудын эдийн засгийн хөгжил эрс түргэсэв. Энэ нь төрийн тогтвортой байдал, хувийн хөрөнгө оруулалтын өсөлт, эдийн засаг, нийгмийн дэд бүтэц сайжирсан, чөлөөт худалдаа явуулснаас ихээхэн шалтгаалсан болох нь зүйн хэрэг. Японы тусламж өнгөрсөн 30 жилд хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлтөд гурван талаар тус үзүүлжээ.

Ази, Дорнод Азийн орнуудад үзүүлсэн тусламж нь тэдгээр орны нийгэм, эдийн засаг, дэд бүтцийн хөгжилд тогтвортой, урт хугацааны хөрөнгө оруулалт болсон.

Японы урт хугацаатай, хүү багатай зээл нь улс орнуудад дунд хугацааны (таван жилийн) хөгжлийн төлөвлөгөөтэй ажиллах боломж олгосон билээ. Түүнчлэн улс орны төлбөрийн тэнцлийг дэмжсэн бөгөөд дээрх уян хатан нөхцөлтэй зээл нь

\*Ц. Баатар. ЗХАСТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, дэд доктор.

урьдчилан төсөөлөхөд төвөгтэй дэлхийн эдийн засгийн өөрчлөлтүүдийг даван туулахад нь тэдгээр орнуудад ихээхэн дэмжлэг болсон юм. «Хүйтэн дайны» дараахи олон улсын харилцааны шинэ нөхцөлд Японы үзүүлэх тусламжийн хэмжээ өсөх шаардлага нэмэгдэхийн зэрэгцээ түүний зориулалтад зарим шинэ хандлага гарч ирсэн юм. Түүний учир шалтгаан гэвэл:

1. Умард, өмнөд өөрөөр хэлбэл хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хөгжлийн хурдацын зөрүү улам өслөө. НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн илтгэлд дурдсанаар 1960 оны байдлаар дэлхийн хамгийн ядуу бүлэг орнуудаас 30 дахин илүү баялаг эзэмшиж байсан бол энэ нь 1991 онд 91 дахин илүү болов. Хөгжингүй орнуудад 400 хүнд нэг их эмч оногдож байхад хөгжиж буй орнууд 7000-д Африкийн нэлээд оронд 36000 хүнд нэг их эмч оногдож байна.

2. Тусламжийн хэмжээ өссөн нь түүнийг авдаг улс орны тоо өссөнөөс болов. ЗХУ задарснаас болж Төв Азийн тав, Кавказд гурван улс тусламж авагч болсон төдийгүй Орос өөрөө, тэрчлэн Дорнод Европын (хуучин социалист) орнууд «хүйтэн дайны» жилүүдэд тусламж үзүүлэгчид байснаа одоо мөн тусламж авагчид болж өөрчлөгдөв.

3. Хуучин Холбооны Югослов, ба Руанда Улс отог, омог, шашин шүтлэгийн тоо өссөн учир тусламж их шаардах болжээ.

4. Тусламж авах шаардлага өсөхийн зэрэгцээ түүний агуулгад өөрчлөлт оров. Урьд тусламж нь нийгэм—эдийн засгийн дэд бүтцийн байгууламж, хүмүүсийг сургахад ихэнхдээ зориулагдаж байсан бол одоо байгаль орчныг хамгаалах, хүн амын хэт өсөлтийг хязгаарлах, ДОХ зэрэг өвчинтэй тэмцэх мэтийн том асуудлуудыг хамрах болов. Мөн ардчилалыг өрнүүлэх, зах зээлийн эдийн засгийн хөгжлийг дэмжих, эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурийг дэмжихэд чиглэх болов.

Дээрх шалтгааныг үндэслэн Японы Засгийн газар 1992 онд өөрийн тусламжийн бодлогын дөрвөн зарчмыг тодорхойлсон юм.

Энэ нь:

1. Байгаль орчныг хамгаалах, ба хөгжлийг дэмжих нь гол зугам байх болов.

2. Тусламжийг цэргийн зорилгод мөн, олон улсын мөргөлдөөнийг даамжруулахад ашиглаж болохгүй.

3. Хүлээн авагч орон тусламжийг цэргийн зардлаа нэмэгдүүлэх үй олноор устгах зэвсэг үйлдвэрлэх, зэвсэг экспортлох буюу импортлоход бус, олон улсын энх тайван, тогтвортой байдлыг бэхжүүлэх, өөрийн нөөц бололцоогоо эдийн засаг нийгмийн хөгжилдөө чиглүүлэхэд бүрэн анхаарна.

4. Ардчиллыг дэмжих, зах зээлийн эдийн засагт шилжих, хүний үндсэн эрх, эрх чөлөөг хангахад чиглүүлэхэд оршино.

Япон улс сүүлийн үед дээрх дөрвөн зарчимаа зарим талаар эргэн харахад хүрч байна. Мьянмарын (Бирма) цэргийн дэглэмийг ганцаардуулах үүднээс АНУ, Англи улс тусламжаа зогсоосон. Гэтэл Японы засгийн газар яриа хэлэлцээ үргэлжлүүлж ардчиллыг нь дэмжих, хүний эрхийн байдлыг сайжруулах зорилгоор тусламжийн яаралтай зүйлд болон хүмүүнлэгийн зориулалтаар олгох хэсгийг үлдээх зэргээр уян хатан хандаж байна. БНХАУ 1995 оны наймдугаар сард цөмийн

зэвсгийн туршилт хийсэнтэй холбогдуулан тусламжийн зарчмаа баримтлан буцалтгүй тусламжаа зогсоож, зөвхөн яаралтай зүйлд болон хүмүүнлэгийн зориулалтаар олгодог хэсгийг үлдээсэн байна. Японы Засгийн газрын тусламж нь **буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл** гэсэн хоёр үндсэн ангиас бүрддэг.

Туйлын ядуу орон нь зээлийг эргүүлж төлж чадахгүй учир тэдэнд буцалтгүй тусламж, мөн техникийн хамтын ажиллагаагаар тусалдаг. Нэлээд хөгжсөн оронд зээл болон техникийн хамтын ажиллагаагаар, түүнээс дээгүүр оронд зөвхөн зээл, өндөр хөгжилд хүрч буй оронд зөвхөн техникийн хамтын ажиллагаагаар тусалдаг. Жишээ болгоход, Япон улс Тайландад зээл болон техникийн хамтын ажиллагаагаар, Малайз, Бразил, Мексикт техникийн хамтын ажиллагаагаар тусалж Сингапур, БНСУ нь өөрсдөө хандивлагч болон хувирч буйг харгалзан тэдэнд технологийг шилжүүлэх хөтөлбөрөөр тус хүргэж байна гэж Японы Гадаад Хэргийн яамны эдийн засгийн хамтын ажиллагааны газрын ерөнхий захирал Ацүжи Хата-Кенака (Look japan) сэтгүүлд бичсэн байна.

Япон улсын Засгийн газрын хөгжлийн тусламж (ОДА) нь өнөөдөр дэлхийн шинэ тулгар хөгжиж байгаа 150 гаруй орныг хамарч тэдгээр орнуудын хөгжлийн явц дахь тулгамдсан хүнд хэцүү асуудлуудыг шийдэхэд ихээхэн хувь нэмэр оруулж байна. Түүгээр ч зогсохгүй тусламжаар дамжуулан улс орнуудын хооронд хүн солилцоо, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэж байна.

Зах зээлийн харилцаанд шилжиж эхэлсэн Монгол улсын эдийн засгийн хөгжлийг дэмжих, тулгамдсан бэрхшээлийг даван туулахад Япон улсын Загийн газар, Засгийн газрын бус байгууллага, Японы ард түмэн манай оронд элгэмсүү сэтгэлээр хандаж зүйл бүрийн тусламж дэмжлэг үзүүлсээр байна. Тусламжийн хэмжээ, хэлбэр агуулга ч жил ирэх бүр өргөжсөөр байна. Өнөөдрийн байдлаар Японы Засгийн газрын тусламж, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээ голлох байр суурь эзэлж байна. 1990 оноос хойш манайх Японоос 250 орчим сая ам.долларын тусламж авч ашиглаж байна. Өнөөгийн байдлаар манай улсын гадаадаас авч буй тусламжийн гуравны нэг Японд оногдож байна. 1994 оны байдлаар Япон улсын тусламж үзүүлсэн 150 гаруй орнуудаас тусламж олгосон хувь хэмжээгээр Монгол улс эхний аравт орж байна. Үүнийг хүн ам тутамд оногдох хэмжээгээр авч үзвэл бүр ч дээгүүр байр эзлэнэ.

Японы Засгийн газрын хөгжлийн тусламж (ОДА)-ийн шугамаар Монголд үзүүлж ирсэн тусламжийг төрөл хэлбэрээр нь арай тодруулан авч үзье. ОДА нь дотроо Засгийн газрын буцалтгүй тусламж, техникийн хамтын ажиллагаа, Засгийн газар хоорондын мөнгөн зээллэг, Олон улсын байгууллагаар дамжуулж олгох тусламж гэсэн төрлүүдтэй. Манай улс ОДА-ийн тусламжийг 1977 оноос авч эхэлсэн.

Засгийн газрын буцалтгүй тусламж, техникийн хамтын ажиллагааны нэг зүйл болох тухайн орны нийгэм, эдийн засгийн хөгжилд зориулсан тодорхой төслийг санхүүжүүлэх зорилго бүхий **төслийн буцалтгүй тусламжийн хөрөнгийг** Японы засгийн газраас манай улсад сүүлийн жилүүдэд ихээхэн хэмжээгээр олгож байна. Тухайлбал 1991 оноос манай улсын эдийн

засгийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд үр нөлөөгөө үзүүлэх олон улсын сансрын ИНТЕЛСАТ холбооны нэгтэрбум 500 сая иений нийт өртөг бүхий газрын станцыг Улаанбаатарт байгуулах төслийг санхүүжүүлэн ашиглалтад орууллаа. Мөн 1992 онд Улаанбаатар хотын 8 эмнэлэгт 9 сая 436,9 мян ам. долларын өртөгтэй оношлогоо эмчилгээний орчин үеийн тоног төхөөрөмжийг суурилууллаа. Монголын төмөр замын ачаа тээвэрлэх, нэвтрүүлэх хүчин чадлыг сайжруулах ачаа шилжүүлэн ачих Замын үүд өртөөний байгууламжийн төслийг нийт 19 сая 700 мянган ам. долларын хөрөнгөөр санхүүжүүлэн, эхний ээлжийг нь энэ 1995 оны 4 дүгээр сард ашиглалтад орууллаа. Дархан хотод мах боловсруулах комбинатын хөргөлтийн системийг шинэчлэн мөн оны 4 дүгээр сард ашиглалтад оруулав. Эдгээр үйлдвэр байгууламжууд нь эдийн засгийн хүнд байдлыг даван туулж, ард пүмний аж амьдралыг дээшлүүлэхэд чухал үр шимээ өгч эхлээд байгаа юм. Улаанбаатарт олон улсын холбооны хиймэл дагуулын системийн газрын станцыг байгуулснаар дэлхийн олон орны телевизийн нэвтрүүлгийг шууд хүлээн авдаг, урьд өмнө ихээхэн төвөгтэй байсан олон улсын яриа, факсаар хоромхон зуурт төвөггүй харилцдаг болсон, өөрөөр хэлбэл дэлхий дахины хэмжээний мэдээллийг манай орны аль ч хэсэгт шууд хүлээн авах сайхан боломж бүрдэж, энэ талаар цаашид хэрэгжих өргөн дэвшлийн эх суурь тавигдлаа. Улаанбаатар хотын нэгдсэн нэгдүгээр эмнэлэг, гуравдугаар эмнэлэг, Эх нялхсын төв, Хавдар судлалын төв зэрэг томоохон эмнэлгүүдэд суурилуулж, тоногдсон оношлогоо эмчилгээний өндөр чадамж бүхий орчин үеийн техник хэрэгсэл, иж бүрэн кабинет нь байгуулагдсан цагаасаа өвчний оношлогоог хурдан шуурхай, зөв тогтоох, ард иргэдийн эрүүл мэндийг сахин хамгаалахад найдвартай техник хэрэгсэл болохоо нэгэнт харуулаад байна. Дашрамд тэмдэглэхэд эдгээр техник төхөөрөмжийг хариуцан суурилуулсан Японы Хитачи медико пүүсээс техник тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хангах үүднээс мэргэжилтнийг илгээн хугацаат үзлэг үйлчилгээ засварыг тогтмол үнэ төлбөргүй хийж ирэв.

Замын үүдийн ачаа шилжүүлэн ачих байгууламжийн ашиглалтад ороод буй эхний ээлжинд Хятад улсаас орж ирэх нарийн болон өргөн төмөр зам, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг шилжүүлэн ачих тавцан, агуулах. ажилчдын 12 айлын гурван орон сууцыг цэвэр бохир усны болон цахилгааны системтэй нь барьжээ. Ачаа шилжүүлэн ачихад зориулсан цахилгаан тэргэнцэр, туузан дамжуулагч тус бүр тавыг нийлүүлжээ.

Цаашид энэ байгууламжийн хоёрдугаар ээлжээр контейнерийн талбай, түүн лүү очсон өргөн, нарийн төмөр зам, өртөөний төмөр замын өргөтгөл, гэрэлтүүлэг болон радио холбооны систем, 12 айлын хоёр орон сууц, гараашийн барилга зэргийг барьж, 40 тонн ачаа өргөх буулгах хүчин чадалтай өөрөө явагч өргөгч машиныг Япон улсаас нийлүүлэх ажээ.

Одоо Японы Засгийн газрын буцалтгүй тусламжаар Улаанбаатар хотын IV цахилгаан станцын хэвийн ажиллагааг хангах хэсэгчилэн тоноглох, хотын сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийг шинэчлэн тоноглох, хотын нийтийн тээврийн

үйлчилгээний найдвартай ажиллагааг хангах, Хархорин, Өндөр хааны гурил тэжээлийн үйлдвэрийн дэргэд үрийн агуулах барих зэрэг томоохон төслүүдийг санхүүжүүлэн хэрэгжүүлэх үе шат нэгэнт эхлээд байна.

Дээр дурьдсан төслийн буцалтгүй тусламжаас гадна эдийн засаг нь зогсонги байдалд ороод байгаа орнуудад олгох зориулалттай. **Төслийн бус буцалтгүй тусламжийг манай улс авч ашиглаж ирлээ.** Ийм тусламжийг Японы засгийн газраас 1987 оноос эхлээд дэлхий дахины олон улс орнуудад хэрэгжүүлжээ. Одоо манай улсыг оролцуулаад дэлхийн 42 оронд энэ тусламжийг үзүүлж байна. Монгол улсыг төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн тогтолцоонд шилжих үеийн эдийн засгийн зогсонги байдлаас гаргаж нийгэм эдийн засгийг нь хөгжүүлэх, манай улсын эдийн засгийн бүтцээ сайжруулах гэсэн хүчин чармайлтыг дэмжих зорилгоор 1991 оноос эхэлж 4 жил дараалан жил тутам 2 тэрбум иенийг олгож ирлээ. Энэ тусламжаар голдуу улс ардын аж ахуйн гол гол салбар эрчим хүч, тээвэр, уул уурхай, хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн салбарт чухал шаардлагатай шатахуун тосологооны материал, уул уурхайн хүнд даацын машин техник, барилгын материал, хөдөө аж ахуйн техник болон бусад төрлийн автомашины сэлбэг хэрэгсэл, дугуй, аккумулятор, эм бэлдмэл зэргийг худалдан авч ашиглаж байна. Энэхүү төслийн бус буцалтгүй тусламжийн нэг онцлог нь тусламжаар авч буй барааг дотооддоо борлуулан хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлж, бий болсон тухайн хөрөнгийг цаашид хэрэгцээтэй зүйлдээ зарцуулах боломжтой байдагт оршино.

Засгийн газрын буцалтгүй тусламжийн өөр нэг хэлбэр болох **Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх** тусламжийг мөн манай улсад үзүүлж ирлээ. Энэ нь эдийн засаг зогсонги байдалд орсон орнуудын нийгэм, эдийн засгийн байдал, хүнсний хангамж, хүнсний нөөц нэмэгдүүлэх төлөвлөгөө зэргийг харгалзан тухайн оронд Засгийн газрын тусламж үр ашигтай болж чадах эсэхийг судалсны үндсэн дээр үзүүлдэг тусламж юм. Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх тусламжаар хөдөө аж ахуйг хөгжүүлэхэд шаардлагатай бордоо, газар тариалангийн хор, хөдөө аж ахуйн машин техник зэргийг нийлүүлдэг ажээ. Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх энэ тусламжийг манай улсад 1991 оноос эхлэн (1991 онд 100 сая иен, 1992, 1993 онд тус бүр 150 сая иен, 1994 онд 200 сая иенээр) 4 жил дараалан олголоо. Жишээлбэл, 1993 онд хөдөө аж ахуйн 14 трактор, 500 тонн ниймэл бордоо, 1994 онд 21 дугуйт тракторыг дагалдах хэрэгслийн хамт, 300 тонн бордоо тусламж болгон өглөө. Тусламжийн «Кубота—М1—300» маркийн трактор нь 100 морины хүчтэй, бүхээг нь зай ихтэй, дотроо радио магнитфон, халуун хүйтэн агаар үлээгчтэй, тос багадах, бохирдох зэрэг гэжиг гарсан үед өөрөө дохио өгдөг мэдрэмтгий техник ажээ. Эдгээр тракторыг одоо Төв аймгийн Залуучууд, Угтаал зэрэг хэдэн компанийн газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглаж байна.

Буцалтгүй тусламжийн хүрээнд багтдаг **техник технологийн хамтын ажиллагааны шугамаар 1991—1994 онд Монголоос аж үйлдвэр, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, соёл шинжлэх ухаан**

ны салбарын төрөл бүрийн мэргэжлийн 200 орчим хүн Япон улсад мэргэжил дээшлүүлж, Японы мэргэжилтэн 100 орчим хүн ирж ажиллажээ.

Японы сайн дурынхныг Монголд ажиллуулах тухай Засгийн газрын хэлэлцээр 1991 онд байгуулагдаж, түүнээс хойш өндөр мэргэжлийн 20—26 хүнтэй сайн дурын хэсэг манай их дээд, дунд сургуульд Япон хэл заах зэрэг ажлыг хийж байна.

1990 оноос хойш техникийн хамтын ажиллагааны хүрээнд япон улсаас манай улсын хууль тогтоомж, төрийн байгууламжийн шинэчлэлтийг судлах Засгийн газрын судалгааны хэсэг 1992 онд, Улаанбаатар хотын ундны усны нөөцийг тогтоох, усан хангамжийн системийг сайжруулах судалгааны хэсэг 1993 онд, Монгол нутгийн цаг агаар, мал аж ахуй, хүн ам зүйн судалгаа хийх японы их дээд сургуулийн профессор багш нарын судалгааны хэсэг мөн 1993 онд тус тус ирж тодорхой хугацаагаар судалгаа шинжилгээний ажил хийжээ.

Техникийн хамтын ажиллагаагаар 1991—1994 онд нийт 24 сая 150,7 мянган ам.долларыг олгож, манай улсын соёл боловсрол, урлагийн байгууллагуудад хөгжмийн зэмсэг, монгол бичгийн компьютер дээд сургуулийн лингафонный кабинет, сургалтын техник хэрэгсэл зэргийг нийлүүлж тусаллаа.

Засгийн газраас олгож ирсэн эдгээр тусламжаас гадна японы байгууллага, олон нийт, хувь хүмүүсээс манай ард түмэнд зориулан их хэмжээний хөрөнгө мөнгө, бараа материалын сайн санааны хүмүүнлэгийн тусламж жил бүр үзүүлсээр ирлээ. Тухайлбал, Токио хотын Итабаши дүүргийнхэн болон бусад олон хот дүүргийн оршин суугчдаас бичгийн хэрэгсэл, ном сурах бичиг, дэвтэр цуглуулан монгол хүүхдүүдэд бэлэглэх ажлыг удаа дараа зохион байгуулав. Токио хотын Чигагийн эдийн засгийн коллежийн профессор хатагтай Фүжимотогийн санаачилгаар монгол эмэгтэйчүүдэд зориулан саван цуглуулах хөдөлгөөн өрнөж, хэд хэдэн удаа манайд савангаа илгээсэн зэрэг хувь хүмүүсийн сайн сэтгэлийн санаачилгаар **Засгийн газрын бус шугамаар** туслах ажил үргэлжилсээр байна.

Мөн Япон монголын найрдамдлын нийгэмлэгээс олон сая иений хүнсний бараа бусад зүйлсийг, Японы Сасагавагийн олон улсын энх тайвны фондоос нэг удаагийн тариур зэрэг эмнэлгийн хэрэгслийн тусламжийг ирүүлдсэн юм. Японы Тайшо компаниас хүмүүнлэгийн тусламжийн дагуу 529 мянган ам.долларын 1565 хайрцаг шархны лентийг илгээжээ. Эдгээрээс гадна олон тооны байгууллага хүмүүсээс ном сурах бичиг, хичээлийн хэрэгсэл, оёдлын машин, хувцас, хунар, хүнсний зүйл, мөнгөн тусламжийг удаа дараа ирүүллээ. Түүнчлэн энэ онд Монгол орныг нөмөрсөн аймшагт түймрийн үед зовсон цагт нөхрийн халуун сэтгэлээр хандаж хэдэн зуун мянган ам.доллар бэлнээр болон бараа материалаар туслав. Японы ард түмэн, Засгийн газар, Засгийн газрын бус олон арван байгууллага эд материал, санаа сэтгэлийн асар их тусламж дэмжлэг үзүүлэв. 1991—1994 онд Японы засгийн газрын урт хугацаатай хөнгөлөлттэй 126 сая ам.долларын зээлийн хөрөнгөөр өргөн хэрэгцээний бараа, нефть, шатахуун худалдан авч зарим чухал төслийг санхүүжүүлэх санхүүгийн эх үүсвэр болгон ашиглалаа. Дархан хотод жилдээ 100 мянган тонн ган цувимал үйлдвэрлэх хүчин чадалтай Хар төмөрлөгийн үйлдвэр барьж 1993

онд ашиглалтад оруулахад 36 сая гаруй ам.долларын арилжааны зээлийг авч ашигласан байна. Энэ үйлдвэрийн бүтээгдэхүүнээс анх удаа энэ 1995 оны эхээр 2000 тонн хар төмрийн бэлдэцийг Япон улсад гаргасан ажээ.

Улаанбаатарын IV цахилгаан станцын сэргээн засварлалт, техникийн шинэчлэлтэд зориулж Япон улсын Засгийн газраас 4 тэрбум 493 сая иений хөнгөлөлттэй зээлийн 30 жилийн хугацаатай, 2.3 хувийн хүүтэйгээр олгожээ. Энэ хөрөнгөөр цахилгаан станцын зуухнуудыг өөрчилж, уг станцад автомат удирдлагын систем нэвтрүүлж, тоног төхөөрөмжийг шинэчлэх ажээ.

Япон улсын Засгийн газрын ОДА-ийн шугамаар үзүүлж буй төрөл бүрийн чиглэлийн тусламжийн нэг хэлбэр нь төлбөрийн балансын алдагдлыг нөхөх зориулалтаар 1991 оноос эхлэн манай улсад жил бүр олгож ирсэн «Санхүүгийн тусламж» юм. Японы Засгийн газар энэ чиглэлээр 1991—1994 онд 7 тэрбум иенийн тусламж үзүүлээд байна. Санхүүгийн тусламжийг олгох үед хоёр засгийн газрын хооронд солилцсон нот бичигт уг тусламжийг хэрхэн ашиглах талаар хийсэн тохиролцоо байдаг. Уг тусламжийн хөрөнгийг ашиглахдаа түүний үйл ажиллагааг зохион байгуулах зөвлөх пүүс сонгон авч гэрээ байгуулна. Түүний дараа нотны хавсралтад дурьдсан барааны дотроос монголын тал хэрэгцээт бараагаа сонгож захиална. Нотны хавсралт жагсаалтад ороогүй барааг захиалах шаардлагатай болсон тохиолдолд Японы Засгийн газар дахин хүсэлт тавьж зөвшөөрөл авна. Захиалсан барааг зөвлөх пүүс судалж Японы худалдааны пүүсүүдийн хооронд тендер зарлаж нийлүүлэгчийг шалгаруулан түүний үр дүнг монголын талтай зөвшилцөж бараа нийлүүлэлтийн гэрээ байгуулна. Гэрээт барааг нийлүүлсний дараа Монголын тал уг барааны үнийг төгрөгөөр тусгай дансанд төвлөрүүлнэ. Тусгай дансанд төвлөрүүлсэн төгрөгийг Монголын эдийн засгийн хөгжлийн зориулалтаар ашиглаж болох ба түүнийг ажиллах тухай бүрдээ Японы талтай зөвшилцөж байх журамтай. Төслийн хэрэгжилт төгрөгийн төвлөрүүлэлт, ашиглалтын талаар Японы талд жил бүр тогтоосон хугацаанд тайлан гаргаж өгөх журмаар энэхүү тусламжийн ашиглалтад хяналт тавьдаг.

Дээрх тохиролцоог хүндэтгэн биелүүлэх учиртай боловч өнөөдрийн байдлаар зарим талаар манай Засгийн газар, холбогдох байгууллагууд хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байдал гаргасаар байгааг Японы тал шүүмжилж байна.

Манай талын гол дутагдал гэвэл төгрөгийн төвлөрүүлэлтийг тусгай данс нээн хийлгүй улсын төсөвт шууд оруулж байгаа; төвлөрүүлсэн төгрөгийг Монголын тал Японы талтай зөвлөлдөлдөггүй шууд зарцуулж ирсэн; Төслийн хэрэгжилт, төгрөгийн ашиглалтын талаархи тайланг Японы талд гаргаж өгөхгүй удаашруулж байгаа; төгрөгийн төвлөрүүлэлт, худалдан авсан барааны боруулалт хэт удааширалтай байгаа зэрэг гол дутагдал «санхүүгийн тусламж»-ийн хувьд ажиглагдаж байна. Энэ бүхнээс үзэхэд манай тал санхүүгийн тусламжийг үр ашигтай ашиглах талаар хангалтгүй ажиллаж байна гэхэд хилсдэхгүй бизээ.

Японы Засгийн газрын ОДА-ийн тусламжийн нэг чухал хэл-

бэр нь улс орны эдийн засгийн хөгжлийн тулгамдсан гол асуудал тухайлбал хөдөө аж ахуй, газар тариалан, дэд бүтцийн тодорхой төслүүдийг хэрэгжүүлэхэд зориулан урт хугацаатай, маш бага хүүтэй хөнгөлөлттэй зээл олгох явдал байдаг. Үүнийг манай улс 1991 оноос эхлэн авч эхэлсэн билээ. Манай улс 1991—1992 оны санхүүгийн жилд 38 сая 673 мянга, 1992—1993 онд 23 сая 262,1 мянга, 1993—1994 онд 6 сая 900 мянга, 1994—1995 онд 13 сая 100 мянган ам.долларын хөнгөлөлттэй зээл аваад байна.

**Хөнгөлөлттэй урт хугацааны зээлийг** манай улс дараах чиглэлээр авч байна. Үүнд:

**Санхүүгийн зээлийг** ихэвчлэн гадаад худалдааны тэнцлийг сайжруулах, төсвийн алдагдлыг багасгах зорилгоор авч ирэв.

Энэхүү зээлийг зөвхөн дээрх хоёр арга хэмжээнд зориулдаг. Өөр ямар нэг онцгой нөхцөл тавьдаггүй.

**Төслийн зээлийг** Монгол улсын эдийн засагт онц чухал ач холбогдолтой, ялангуяа дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэсэн объектуудыг барьж байгуулахад зориулан авч байна.

**Хөтөлбөрийн зээлийг** эдийн засгийн гол салбарын бодлогыг зөв хэлбэрт оруулахын тулд тодорхой нөхцөл, шаардлагатайгаар авч байна.

Хөтөлбөрийн зээл нь манай бодлогыг зах зээлийн зөв зарчимд тулгуурлан хөгжүүлж хүмүүсийг бүтээлч ажил, чиглэл рүү хандуулж байгаа учир алсдаа үр дүн өгөх үндэстэй. Дэлхийн өндөр хөгжсөн бараг бүх оронд нааштайгаар үйлчилсэн хөтөлбөрийн зарчмууд Монголд мөн адил үр дүнгээ өгөх нь зайлшгүй.

**Барааны зээлийг** манай улс голчлон бараа бүтээгдэхүүнээр бага зэрэг авч байна.

Манай улс зээл тусламжийг тэр бүр үр ашигтай ашиглахгүй байгааг Японы тал шүүмжилж байдаг. Үүнийг манай төр засгийн холбогдох байгууллагууд хүлээн зөвшөөрдөг. 1995 оны аравдугаар сард Монгол улсын Гадаад харилцааны сайд Ц. Гомбосүрэн Япон улсад албан ёсны айлчлал хийх үеэр Японы тал энэ тухай тодорхой баримтаар ярьсан билээ. Тухайлбал, Улаанбаатарын сүүний үйлдвэр, Дарханы мах комбинатын тоног төхөөрөмжийг шинэчлэхэд зориулж тус бүр 10 сая ам. долларын буцалтгүй тусламж олгожээ. Гэтэл сүү, сүүн бүтээгдэхүүн, махан бүтээгдэхүүний хангамж чанар муу байгаа тухай мөн Улаанбаатар хот, 8 аймаг, 47 суманд өгсөн орчин үеийн оношлогоо, эмчилгээний төхөөрөмжийг цахилгаан байхгүй сэлбэг туслах материал дутуу зэргээс шалтгаалан ашиглагдахгүй байгаа, таван жил гаруй хамтарч ажилласан хэрнээ хамтын ажиллагааны талаархи хүсэлт, түүнтэй холбогдсон баримт материалаа зохих журмын дагуу ном ёсоор нь бүрдүүлж өгч чадахгүй байгаа зэрэг болно.

Үүнийг манай тал хойшид анхаарахгүй бол зээл тусламж «ёроолгүй саванд» орж байна гэж үзээд олгох хэмжээгээ багасган хязгаарлаж болзошгүй.

Япон улс сүүлийн үед Зүүн хойт Азийн бүс нутгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангахын төлөө ихээхэн хүч анхаарал тавих болсон билээ.

Чухамхүү энэ хүрээнд Зүүн хойт Азийн бүс нутгийн орнуудаас хамгийн буурай хөгжилтэй, хөгжиж байгаа Монгол орныг

бүс нутгийн интеграцид нэгдэх боломжийг богино хугацаанд бүрдүүлэхэд чиглэсэн Японы ард түмэн, түүний засгийн газрын чин сэтгэлийн сайн санааны бодит илрэл нь энэхүү зээл тусламж болж байгаа юм.

#### Ашигласан материал

1. Үндэсний хөгжлийн газрын тоо баримт
2. «Засгийн газрын мэдээ» 1994, №37, 181, 189.
3. «Ардын эрх», 1995.2.10, 6.6. 11, 17, №110, 202, 232.
4. «Зүүн хойт Ази судлал», 1995, №1—2.
5. Энэхүү өгүүлэлд Япон судлаач Б. Сэржавын цуглуулсан материалыг өргөн ашиглав.